

АГУУЛГА

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	1
2. ПАБЛИК СЕРВИС ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ГОЛ ЗОРИЛТ	6
3. СӨРӨГ НӨЛӨӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	7
3.1 Агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	7
3.2. Газар доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	7
4.3 Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр.....	8
3.4. Ургамал, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	8
4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	9
5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	10
6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	11
7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	11
8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ.....	12
9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ	13
10.1 Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим	14
10.2 Хог хаягдлыг зайлцуулах, устгах арга зам.....	14
10. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	16
12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	17
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА	
18	

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Паблик Сервис” ХХК нь “Энержи Ресурс” ХХК-ийн “Ухаа худаг” нүүрсний уурхайн зөвшөөрөгдсөн 6116 м.кв талбайд уурхайн бүсээс гарч буй 10 нэр төрлийн аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, түр хадгалах үйл ажиллагааг эрхэлдэг бөгөөд жилд 4000-5000 м.куб аюултай хог хаягдлыг татан зайлцуулдаг. Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн засварын төв, дэд бүтцийн бусад барилга байгууламж, үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, ангилан ялгах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлдэг.

Паблик Сервис компани нь 2009 онд Ухаа худаг уурхайн төслийн талбайгаас гарч буй хог хаягдлын менежментийг холбогдох хууль журамд нийцүүлэн хэрэгжүүлэх зорилготойгоор Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт үүсгэн байгуулагдсан.

Манай компани нь 2009 онд 5 ажилтантай үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол 2024 оны байдлаар тогтмол 28 ажилтан, хог тээврийн гурван машин, ажилчдын нийтийн тээвэр нэг, ажиллагсдын өдрийн гал тогоо, оффис, дахиварын цех зэрэг хог хаягдлын үйл ажиллагааг цогцоор нь эрхлэх хүчин чадал, нөөцтэй болж үйл ажиллагаагаа тасралтгүй тогтмол явуулж байна.



Зураг 1.1. Дахиврын цех өдрийн гэрэл ангилан ялгат

Хүснэгт 1.1. Хог хаягдал ангилан ялгах болон дахиврын цехийн координат

д/д	Өргөрөг	Уртраг
1.	43 41 39.4	105 32 23.8
2.	43 41 40.1	105 32 25.7
3.	43 41 38.7	105 32 26.7
4.	43 41 38.0	105 32 24.9
5.	43 41 37.4	105 32 21.6
6.	43 41 39.1	105 32 20.9
7.	43 41 39.4	105 32 22.9
8.	43 41 39.5	105 32 23.7

Тус талбайг Газрын тухай хуулийн 35-р зүйлийн 35.1.6 дахь заалт, Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 83-р тушаалыг үндэслэн Сумын засаг даргын 2020 оны 4-р сарын 28-ний өдрийн А/102 дугаартай захирамжаар 4604000328 нэгж талбарын дугаартай, Ухаахудаг уурхайн ард талд байршилтай, барилга байгууламжийн зориулалт бүхий Энержи Ресурс ХХК-ийн эзэмшил газраас 0.611 га газрыг аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, ангилан ялгах цехийн зориулалтаар компани хоорондын гэрээний дагуу ашиглаж байна.

Үндсэн үйл ажиллагаа


“Паблик Сервис” ХХК нь Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх түр зөвшөөрлийг Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас 2022 оны 4-р сарын 28-ны өдөр гэрчилгээжүүлж авсан ба 2023 оны 5-р сарын 22-ны өдөр дахин 2 жилийн хугацаатайгаар сунгасан байна.

The image shows two certificates issued by "Паблик Сервис ХХК".
The left certificate is titled "АЮУЛГАЙ ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТҮР ЗӨВШӨӨРӨЛ". It details a survey project for a land area of 0.611 ha, starting on April 22, 2022, and completed on May 22, 2023. It includes technical details like coordinates (43 41 39.5, 105 32 23.7) and a map reference (37-2-201). It features a blue decorative border and a red seal at the bottom.
The right certificate is titled "ТУР ЗӨВШӨӨРӨЛ". It lists five survey points with their coordinates and times. It also includes a map reference (37-2-201) and a red seal at the bottom. Both documents mention "БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЧЫНДАЛЬН САЙД" (Land Surveying and Registration Agency) and "Б.БАТ-ЭРДЭНЭ" (B.BAT-ERDENE).

Зураг 2.2. Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх түр зөвшөөрөл

Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчны төлөв байдал

Хүн ам, эдийн засаг, зам харилцаа: Цогтцэций сум нь 72.5 хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, нийслэлээс 540 км, аймгийн төвөөс 100 км зайд, Цогт-Овоо, Манлай, Баян-Овоо, Ханхонгор, Ханбогд, Номгон сумдтай, Дундговь аймгийн Өлзийт сумтай хиллэн, далайн түвшингээс дээш 1200-1791 м-ийн өндөрлөгт орших бөгөөд бүхэлдээ говь цөлийн бүсэд хамаарна. Цогтцэций суманд Сийрст, Билгэх, Цагаан-Овоо, Өгөөмөр гэсэн 4 багийн нийт 1766 өрхөд 5180 хүн амьдардаг. Уул уурхайд ажилладаг 19 мяангани орчим түр оршин суугчтай. Хүн амын тоогоор Өмнөговь аймгийн 15 sumaас 1-т, газар нутгийн хэмжээгээр 11-д ордог. Аймгийн төвийг оролцуулалгүйгээр хүн амын нягтралаар 5.49 хүн/га сум юм.



Төсөл хэрэгжиж буй бүс нутаг нь байгалийн мужлалаар Говийн их мужийн бор хөрний бүсэд багтах ба газрын гадарга, газарзүйн хувьд нам уулс ухаа гүвээ толгодод хамрагдана. Хөрний хээрийн судалгаа ба лабораторийн шинжилгээний үр дүнд үндэслэлж доор дурьдсан хөрний хэв шинж, дэд хэв шинж, төрөл, зүйлийг тогтоосон. Үүнд:

- Нам уулс, ухаа гүвээ толгодын сүл хөгжилтэй чулуутай бор хөрс
- Цөлөрхөг хээрийн тал хөндийн үүрмэг чулуутай бор хөрс
- Цөлөрхөг хээрийн тал хөндийн чулуутай бор хөрс
- Цөлөрхөг хээрийн нугархаг хөрс
- Гуу жалга сайрын хөрс

Уур амьсгалын тойм

Даланзадгад хотын сүүлийн 10 жилийн агаарын температурын мэдээнээс харахад жилийн агаарын дундаж температур нь 5.8°C байна. Цогтцэций сумын жилийн агаарын дундаж температур 4.3°C байдаг байна. Жилийн хамгийн хүйтэн сар нь 1 дүгээр сар буюу дундаж агаарын температур нь $12.9 - 13.7^{\circ}\text{C}$, хамгийн дулаан сар нь 7 дугаар сар буюу дундаж агаарын температур нь $+23.1 - +24.5^{\circ}\text{C}$ байдаг байна. Уур амьсгалын дулаарлаас болж жилийн хүйтэн үеийн үргэлжлэх хугацаа, хүйтний нөөц багасч, дулаан үеийн үргэлжлэх хугацаа уртасч дулааны нөөц нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Энэ бүс нутагт жилдээ 104.3 мм орчим хур тунадасны хэмжээ жилийн дотор нилээд өөрчлөлттэй хуваарилагддаг буюу 4-10 дугаар саруудад жилийн нийт хур тунадасны 6893% нь унадаг боловч зөвхөн 7-8 дугаар саруудад 60-70% орчим нь унадаг байна. Сүүлийн жилүүдэд уур амьсгалын дулаарлаас шалтгаалан зүсрэн орох бороо цөөрч гол төлөв хүчтэй аадар борооны тоо олшрох болсон. Жилийн дундаж салхины хурд $2.4 - 5.1 \text{ м/сек}$ ба сүүлийн 10 жилд салхины хурд хамгийн ихдээ 30 м/сек хүрч ширүүсч байсан байна. Төслийн бүс нутагт хаврын улиралд салхины хурд харьцангуй их буюу $4.3 - 5.1 \text{ м/сек}$ хурдтай байдаг. Өвлийн улиралд баруун, баруун хойд, хойд

чиглэлийн салхи зонхилж байснаа зуны улиралд өмнөд зүгийн салхины давтагдал нэмэгдэж ирдэг зүй тогтолтой. Агаарын харьцангуй чийгшлийн их утга нь өвлийн саруудад ажиглагдах бөгөөд 1 ба 12 дугаар саруудад 50-68% байна. Хавар намарт агаарын харьцангуй чийгшлийн бага утга буюу 22-47% ажиглагдана.

2. ТӨСЛИЙН ҮНДСЭН БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Паблик сервис ХХК-ийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, ангилан ялгах, дахин ашиглах үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлүүдийг тус компанийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тодорхойлсон байдаг. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, ангилан ялгах, дахин ашиглах үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

1.I.1.1 2.1. Агаарын чанарт үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Үндсэн сөрөг нөлөөллүүд:

- Хог хаягдлын тээвэрлэлтээс агаарт тоосонцорын хэмжээ ихсэх
- Хог хаягдалд агуулагдах тосолгооны материал, химийн бодисын үлдэгдлээс агаар орчинд бохирдол үүсэх,
- Хог хаягдлын турбо бурнер зуухны филтер бохирдсоноор агаарт хорт хий ялгараах;

Болзошгүй сөрөг нөлөөллүүд:

- Хог хаягдлын ангилан ялгах хэсэгт гол түймрийн болзошгүй эрсдэл үүсэх
- Төслийн хэмжээнд ашиглаж байгаа хатуу хучилттай зам эвдрэх, зам засах зэргээс шалтгаалан шороон зам гарган ашигласнаас агаарт тоосжилт үүсэх
- Дахиврын цехэд хог хаягдлыг дахин боловсруулах үйл явцад гагнуур ашигласнаар агаарт хорт хий ялгараах;

1.I.1.2 2.2. Усны чанарт үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Үндсэн сөрөг нөлөөлөл:

- Аюултай хог хаягдал хадгалах талбай хур тунадсы нөлөөгөөр угаагдалд орж бохирдол тархах.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Хаягдал тос юулэх тээвэрлэх үед нефтийн бүтээгдэхүүн алдагдаж хөрс усыг бохирдуулах.
- Бохир усны шугам халих, эвдрэл үүссэнээр хөрс бохирдох, хөрсний бохирдлоор дамжин ус бохирдох;

2.3. Хөрсний чанарт үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Үндсэн сөрөг нөлөөлөл:

- Хог хаягдлыг цуглуулах ангилан ялгах талбайгаас хэтрүүлэн хурааснаар хөрс бохирдох
- Тос тосолгооны материалаас хөрс бохирдох

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Салаа зам үүсгэнээс шалтгаалан хөрс эдэгдэл эвдрэлд орох.
- Тос тосолгооны материал, бохир ус асгарснаас шалтгаалан хөрс бохирдох.

- Хатуу хог хаягдлыг зөвшөөрөлгүй газар хаяснаар хөрс бохирдох.

1.I.1.3 2.4. Ургамлан бүрхэвчид үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллиүд

Үндсэн сөрөг нөлөөлөл:

- Тээвэрлэлтийн үед ургамлан бүрхэвч устах.
- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орж тухайн хэсгийн ургамлан бүрхэвч доройтох.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Салаа зам үүсгэнээс шалгаалан хөрс эдэгдэл эвдрэлд орж ургамлан бүрхэвчид нөлөөлөх.
- Тос тосолгооны материал, бохир ус асгарсанаас шалтгаалан ургамлын ургалтанд нөлөөлөх.

1.I.1.4 2.5. Биологийн төрөл зүйлд үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллиүд

Үндсэн сөрөг нөлөөлөл:

- Хог хаягдлын хяналтгүй тархалтаас шалтгаалан амьтны амьдрах орчинд нөлөө үзүүлэх;
- Хог хаягдаар амьтад хооллох, орооцолдох зэргээс эрсдэл үүсэх;

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Тээврийн зам хөндлөн гарах амьтад машинд дайруулах.

3. ПАБЛИК СЕРВИС ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, устгах үйл ажиллагаа эрхэлдэг Паблик сервис ХХК-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОНХЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-г баримталсан. Цогтцэций суманд хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, устгах үйл ажиллагаа эрхэлдэг Паблик сервис ХХК-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтуудыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Үйл ажиллагаанаас үүдэлтэй болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах
- Хог хаягдлын дахин ашиглалт боловсруулалтыг нэмэгдүүлэх
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэх
- Хог хаягдлаас үүсэх аливаа сөрөг нөлөөллийг бууруулах үүднээс мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах
- Орон сууцны хорооллууд болон үйл ажиллагаа эрхэлж буй нутаг дэвсгэрт хог хаягдлын чиглэлээр тулгамдаж буй асуудлын гарц гаргалгаа шийдлийг олоход хувь нэмрээ оруулах;
- Нийтийг хамарсан нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах;
- Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Цэций хорооллын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчлах хамгаалах;

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2024 онд нийт 5.0 сая төгрөг шаардагдах бөгөөд Паблик сервис ХХК байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагын нехөн сэргээлтийн тусгай дансанд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулсан.

Энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан зардал нь байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний урьдчилан тодорхойлогдох боломжтой хэсэг бөгөөд шууд гүйцэтгэлээр тодорхойлогдох, үйл ажиллагааны зардлаар хийгдэх зарим ажлуудын зардлыг энд оруулаагүй болно.

Паблик сервис ХХК 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 12 дугаар сард багтаан БОАЖЯ-д хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батлуулан ажиллана.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	2	3	4	5	6	7	8	9

3.1 Агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

1.	Хог хаягдлыг дахиврын цехрүү тээвэрлэлтээс тоосжилт үүсэх зам, талбайг услах, замын түйрэнг хусах	Ил уурхай	м³/cap	Үйлдвэрлэлийн зардлаас	Нийт зам	Үйлдвэрлэлийн зардлаас	Үйл ажиллагааны нийт хугцаанд	Агаарын тухай хууль,
2.	Хог тээвэрлэх техник хэрэгслүүдээс хорт хий стандартаас хэтэрч ялгарахаас сэргийлж, үзлэг засварыг тогтмол хийх	Авто парк	ш	Үйлдвэрлэлийн зардлаас	4 машин	Үйлдвэрлэлийн зардлаас		Агаарын тухай хууль,
3.	Хог тээврийн машинуудын үр ашгийг нэмэгдүүлэх, маршрутын дагуу тээвэрлэлтийг хийж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор GPS болон түлшний зарцуулалт хянах төхөөрөмж суурьлуулах	Нийт машинууд	ш	500.0	5 машин	2'500.0		Компанийн дотоод журам
4.	Хаягдал бочка болон тосны филтерийн тосыг халууны агаар арилгах процессоос үүдэлтэй агаарт гарах бохирдлыг бууруулах үүднээс турбо бурнерийг зааврын дагуу ажиллуулах;	Дахиврын цех	ш	Үйл ажиллагааны зардлаас	2	Үйл ажиллагааны зардлаас		Агаарын тухай хууль,

3.2. Газар доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

5.	Цэций хорооллын дотор сангийн холболт, айл өрхийн усны шугамгаас ус үр ашиггүй алдагдахаас сэргийлж 24 цагийн	Цэций хороолол	хоног	Үйл ажиллагааны зардлаас	тогтмол	Үйл ажиллагааны зардлаас	365 хоног	Усны тухай хууль
----	---	----------------	-------	--------------------------	---------	--------------------------	-----------	------------------

	сангийн дуудлагын утас, сантехникчийг ажиллуулах						
6.	Ус түгээлтийн худгууд дээр усыг үр ашиггүй асгараахаас сэргийлэх, дотоод хяналт хийх.	Нийт түгээх худгууд	ш	Үйл ажиллагааны зардлас	3	Үйл ажиллагааны зардлаас	Улирал бүр Усны тухай хууль
4.3 Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр							
7.	Дахиврын цехийн хатуу хучилттай талбайгаас бусад хэсэгт хог хаягдлыг тархаахгүй байх;	Ил уурхай	м ³	Захиалагч талын зардлаас	-	Захиалагч талын зардлаас	Хог хаягдлын тээвэрлэлтэд хяналт тавих
8.	Хог хаягдал тээвэрлэх явцад тэвшнээс хог унах бутрахгүй байх нөхцлийг бүрдүүлж хийсч тархаж болзошгүй хаягдлыг битүү машинаар тээвэрлэх;	Ил уурхай	1		-		Жилд 1 удаа ХХЦСТ хууль
9.	Хаягдал тос соруулах үйл явцын үед хөрс бохирдоогоос сэргийлж тогтмол хяналт тавьж, бүртгэл хөтлөх	Тос соруулах цэгүүд	-		-		Тос соруулах тохиолдол бүрт хяналт тавих Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
10.	Нефтийн бүтээгдэхүүний үлдэгдэл агуулсан хогийг хатуу хучилттай талбайд авч, үлдэгдэл тосыг шавах;	Дахиврын цех	ширхэг	Үйл ажиллагааны зардлас	100 почка	Үйл ажиллагааны зардлаас	Тогтмол Хог хаягдлын тухай хууль
11	Тосоор бохирдсон хөрс цуглуулах талбайд саармагжуулалтыг хийх,	Бохирдсон хөрсний талбай	-	Захиалагч талын зардал	1	500.0	Тогтмол Хог хаягдлын тухай хууль
3.4. Ургамал, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр							
12.	Дахиврын цех орчимд ургамлан бүрхэвч талхлагдахаас сэргийлж хөрсний элэгдлээс хамгаалах зорилгоор салаа зам үүсгэхгүй байх;	Дахиврын цех	-	Үйл ажиллагааны зардлаас	тогтмол	Үйл ажиллагааны зардлаас	Жилд 1 удаа Хөрс хамгаалах, цөлжилтөөс

								сэргийлэх тухай хууль
13.	Хог тээвэрлэх явцад зам хөндлөн гарч байгаа жижиг хөхтөн болон бусад амьтыг зам хөндлөн гарах боломжоор хангах; Жолооч нарт түүлбокс орох;	Хог тээвэрлэлийн замын дагуу	-	-	-	-	Жилд 1 удаа	
14.	БОАЖГ-аас явуулдаг хулгайн антай тэмцэх сургалт мэдээллийг байгууллага дотроо сэдэвчилсэн яриа байдлаар таниулах;	Нийт ажилчид	Xүн/ цаг	20	1 удаа	300.0	Жилд 1 удаа	
Нийт				3'300.0				

5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян,төг	Нийт зардал, мян,төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Тэр бум мод хөтөлбөрийг хэрэгжүүлж хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх	Ажилдын хотхон орчмын мод тарьсан талбайн модны усалгаа, арчилгааг зохион байгуулах, нөхөн тарилт хийх.	ш	1000	1.0	1000.0	4-10 сар хүртэл	Монгол улсын ерөнхийлөгчийн зарлиг , Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
2.		Цэций хороолол орчмын нийтийн эзэмшлийн талбайд ПС ХХК-ийн хариуцан тарьсан 440мкв талбайн арчилгаа, усалгааг хийх.	мкв	440	Захиалагч талын зардлаас		7-8-р сард	
Нийт				1000.0				

6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд Паблик сервис ХХК дээр хийсэн БОННҮ-нд тусгайлан заасан ажлууд байхгүй боловч бид тус ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций суманд дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Цогтцэций орчимд нүүдлийн цагаан зээрэнд идэш тэжээл хангах	Биотехникийн арга хэмжээ зохион байгуулж дахиврын цехийн хойд талбайд нутагладаг зээрэнд өвс тавьж өгөх.	Ухаахудаг уурхайн хойд хэсэг	20	15,000.0	300.0	Жилд 1 удаа	Амьтны аймгийн тухай хууль
2.	Зэрлэг амьтдын амьдрах орчныг сайжруулах	Амьтдын амьдрах орчинг сайжруулах зорилгоор талбай орчмын цагаан зээрийн бэлчээрийн талбайн хог хаягдлыг тогтолцоулж түүж цэвэрлэх,	Ухаахудаг уурхайн хойд хэсэг	2 га	Үйл ажиллагааны зардлаас		Жилд 2 удаа	БОНБҮ-ний тухай хууль
Нийт					300.0			

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус компанийн нөлөөллөөр одоогоор нүүлгэн шилжүүлэх өөр айл өрх байхгүй тул энэ онд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаатай холбоотой ажил уг төлөвлөгөөнд тусгагдаагүй болно.

8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны хувьд түүх соёлын өвийг хамгаалах чиглэлээр үргэлжлэн хийгдэх ажил төлөвлөгдөөгүй бөгөөд цаашид түүх соёлын өвийг хамгаалах чиглэлээр шаардлагатай бол тухай бүр шаардлагатай арга хэмжээг санаачлан зохион байгуулна.

9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ

	Болзошгүй аюул, осол, сорөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Ажиллагсдын мэдлэг дутуугаас аюул эрсдэлд өртөх	Аюулгүй ажиллагаа, осол эрсдлээс урьдчилан сэргийлэх сургалтанд хамруулах	ПС нийт ажилчид	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардлаас	1-р улиралд	ХАБЭА тухай хууль Гамшигаас хамгаалах хууль	
2.	Галын аюулын үед хэрэгжүүлэх арга хэмжээ мэдлэг дутуугаас үүсэх эрсдэл	Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг хийх	ПС нийт ажилчид	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардлаас			
3.	Галын хорны бэлэн байдал хангагдаагүйгээс аюул эрсдэл үүсэх	Галын эрсдэлээс сэргийлэх практик болон онолын сургалтыг нийт ажилтнуудад орох	ПС нийт ажилчид	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардлаас	2-р улирал	Гамшигаас хамгаалах тухай хууль	
4.	Аюултай хог хаягдлын аюулгүй байдал алдагдсанаас гарах эрсдэл	Аюултай хог хаягдалтай хэрхэн харьцах, болон түүнтэй холбоотой заавар боловсруулах, ажилчдад танилцуулах	Ангилан ялгагч болон жолооч нар	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардлаас			
5.	Тос тосолгооны материал хадгалах талбайд гал болон үер усны аюулд өртөх	Тос тосолгооны хаягдал материал хадгалах талбайд тэмдэг тэмдэглэгээг сайжруулах, үерийн хамгаалалтын үзлэг хийх;	Дахивар цех	Жилд 1 удаа	500.0	3-р улирал	Гамшигаас хамгаалах тухай хууль	
Нийт					500.0			

10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

№	Хог хаягдлын ангилаал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Энгийн хог хаягдал	Нийт хог хаягдлын бодит хэмжээг тооцоолох зорилгоор жижиг оврын жин болон хогны машинд зориулагдсан пүү ажиллуулах	Уурхай орчим	ш	400'0	1	2'400'0	Өдөр бүр хуваарийн дагуу	Хог хаягдлын тухай хууль
2		Уурхай орчмын зам талбайд цэвэрлэгээ зохион байгуулах	Уурхай орчим	-	-	4	Энержи Ресурс ХХК захиалгаар	Улирал тутам	
3		Хуванцарын хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Хог хаягдал түр хадгалах цэгүүд	м ³	-	-	Үйл ажиллагааны зардлаас	Тогтмол	
4.	Аюултай хог хаягдал	Хаягдал тосыг шаардлага хангасан нөхцөлд цуглувуж, эрх бүхий байгууллагад нийлүүлэх	Засварын төв	тн	-	10	Үйл ажиллагааны зардлаас	Улирал тутам	Хог хаягдлын тухай хууль
5		Аюултай хог хаягдлын зохицуулалтыг сайжруулж 2-с доошгүй хаягдлын зохицуулалтыг сайжруулах;	Дахиврын цех	ш	500.0	2	1,000.0	2-р улиралд	
6		Хог хаягдаар дахивар бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагааг явуулах	Хаягдал тосны филтер	ш	-	700	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш	
7.		Аюултай хог хаягдлыг нийлүүлэгч тал болон эрх бүхий байгууллагад буцаан хүргүүлэх, нийлүүлэх	Хаягдал тос, Тосны сав, Аккумулятор	ш	-	30-50	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш	
Нийт							3,400.0		

10.1 Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим

Баруун наран төслийн хог хаягдлын менежментийн үндсэн зарчим нь дараах байдлаар тодорхойлогдоно. Төслийн хүрээнд хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх зорилгоор Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын журмыг даган мөрддөг.



Зураг 10.1. Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим

10.2 Хог хаягдлыг зайлцуулах, устгах арга зам

Хог хаягдлын ангилан ялгалт

Хог хаягдлын менежментийг үр ашигтай явуулахад хог хаягдлын ангилан ялгалт нэн чухал бөгөөд хаягдлыг зайлцуулах тохиромжтой зөв арга замыг тогтоож өгдөг. Ангилан ялгалтыг хог хаягдлыг эх үүсвэр дээр ба хог хаягдлыг хүлээн авах нэгдсэн цэг дээр явуулдаг. Эх үүсвэр дээрх хог хаягдлын ангилан ялгалтыг хялбар, үр дүнтэй байлгах зорилгоор өнгөөр кодчилсон ба хог хаягдлын төрлөөр хаягжуулсан савнуудыг шаардлагатай цэгүүд дээр байрлуулж ашигладаг (Хүснэгт 7.2.1).

Хүснэгт 10.2.1 Хогийн савны өнгөний код

№	Хогийн савны өнгөний код	Өнгө	Хаягдлын төрлүүд
1.		Ногоон	Хатуу хог хаягдал
2.		Шар	Хуванцар сав
3.		Улаан	Тосоор бохирдсон хаягдал

11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Үрьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
	1	2	3	6	7
1.	Аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, устгах тусгай зөвшөөрлийг сунгуулах;	-		ПС ХХК удирдах албан тушаалтан	“Паблик Сервис” ХХК нь Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх тур зөвшөөрлийг Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас 2022 оны 4-р сарын 28-ны өдөр гэрчилгээжүүлсэн ба 2023 оны 5-р сарын 22-ны өдөр дахин 2 жилийн хугацаатайгаар сунгасан бөгөөд 2025 онд сунгалт хийлгэх:
2.	Байгаль орчны хууль, журмын хэрэгжилтийг хангах зорилгоор дотоод хяналтыг хэрэгжүүлэх	200.0	III	Менежер	Нийт ажлын байрнууд дээр хуваарийн дагуу үзлэг хяналт хийж, үл тохирол илэрвэл залруулах
3.	Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрийдэд сургалт, мэдээллийн ажил зохион байгуулах	500.0		ПС ХХК удирдах ажилтан	Бүх нийтээр түгээмэл тэмдэглэдэг 2 доошгүй өдрийд
4.	Цэций хорооллын СӨХ-ны ажлыг удирдан зохион байгуулах	-	III улирал	ПС ХХК-ийн захирал	СӨХ байгуулж, төлөвлөгөө гарган ажиллах;
5.	Хог хаягдлын менежментийн гүйцэтгэлийг захиалагч талд үнэлүүлж дүгнүүлэх;	-	Сар бүр	Менежер	Сар бүр хийсэн ажлуудын тайланг гаргаж гүйцэтгэлийн үнэлгээ хийлгэсэн байх.
6.	Хот суурингийн ус түгээх байрны ашиглалт засвар үйлчилгээ цэвэр бохир усны шугам сүлжээний тусгай зөвшөөрлийг сунгуулах;	973.0	II	Менежер	
Нийт					1'673.0

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1.	Хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, устгах дахин боловсруулах үйл ажиллагаанаас ялгарах хүлэмжийн хийн тооцооллыг хийх	Компанийн хэмжээнд	Жилд 2 удаа	2	500'0			ISO14064:2015
	Хог хаягдлын дахиврын цэгийн орчмын хөрсний бохирдлыг хянах зорилгоор хүнд металлын шинжилгээ хийлгэх;	БОННҮ-д тогтоосон 2 цэгт	Жилд нэг удаа	1	100.0			MNS 5850: 2019 Хөрс бохирдуулагч элментүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2.	ПС ХХК-ийн үйл ажиллагаа явуулдаг ундны ус түгээх худгуудад усны ерөнхий химийн шинжилгээ хийлгэх	Нийт 3 түгээх худаг	Жилд нэг удаа	1	240.0			MNS 900: 2018 Ундны усны эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3.	Хог хаягдлын цэг орчмын ургамлан бүрхэвчийн талхагдлыг хянах зорилгоор ургамлын бичиглэл хийх;	Дахиврын цех орчмын 2 цэг, харьцуулах 1 цэг	Жилд нэг удаа	1	100,0			БОНБҮТ ХУУЛЬ
4.	Хог хаягдлын дахиврын цех орчмын агаарын бохирдлыг хянах зорилгоор мэргэжлийн байгууллагаар агаарын шинжилгээ хийлгэх;	Орчны агаарын сорьц	Жилд нэг удаа	1	150.0			MNS4585:2016 Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага
Нийт					1090'0			

**13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД,
ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ**

№	БОХТ-ний биелэлтийг тайлagnaад оролцогч талууд	Тайлagnaх хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлagnaх зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Хүргэх газар
	1	2	3	4	5	6	7
1.	Багийн иргэдийн нийтийн хуралд оролцож мэдээлэл өгөх	Ярилцах, Хэмжилт хийх	Хог хаягдлын менежмент	Багийн нийтийн хурал зохион байгуулагдах үед	-	ПС ХХК	Цогтцэций сум Өгөөмөр баг
2.	Холбогдох тайлан мэдээллийг төрийг захиргааны төв байгууллагад хүргэх	Бичгэн	ПС ХХК-ийн үйл ажиллагаа	Жилд 1 удаа	-	ПС ХХК	Цогтцэций сумын ЗДТГ
3.	Хог хаягдлын статистик мэдээ	Бичгэн	Менежмент хийсэн хаягдлын тоон мэдээлэл	Жилд 1 удаа	-	ПС ХХК	БОСШТ
4.	Сарын үйл ажиллагааны тайлан	Албан мейл	Үйл ажиллагааны тайлан	Сар бүр	-	ПС ХХК	Захиалагч компани
Нийт					0		

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

Паблик сервис ХХК-ийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсвийн задаргааг доорх хүснэгтэд харуулсан ба тус зардлын 50% болох 5'931'500 төгрөгийг төрийн сангийн 100111455410 тоот дансанд байршуулж, баримтыг хавсаргав.

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсвийн төрөл	Төлөвлөсөн төсөв сая.тог
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ба бууруулах арга хэмжээ	3.3
2	Нөхөн сэргээлт	1.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	0.3
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	0.6
5	Түүх соёлын өвийг хамгаалах	-
6	Осол эрсдэлийн менежмент	0.5
7	Хог хаягдлын менежмент	3.4
8	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	1.673
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1.09
10	Олон нийтэд тайлагнах үйл ажиллагаа	0
Нийт		11.863

Барьцаа хөрөнгө байршуулсан баримт

ХасБанк маяг № 11316-08

ТӨЛБӨРИЙН БАРИМТ

TRANSFER OF FUNDS

ХАСБАНК

Салбар Branch ЦОГЦЭЦИЙН	Он Year 2025	Cap MM 05	Өдөр DD 19	Мөнгөний нэгж Currency Бэлэн бусаар Non cash <input type="checkbox"/> Бэлнээр Cash <input type="checkbox"/>
XHNEES FROM	Нэр Customer name Пабликсервис			Tөлбөрийн зориулалт Details of payment БОМТ БАРЬЦАА 2025 ОН РД:3614263
XEND TO	Дансны дугаар Account № 5000976244			
Dun Amount 5,931,500.00	Бичгээр In writing ТАВАН САЯ ЕСӨН ЗУУН ГҮЧИН НЭГЭН МЯНГА ТАВАН ЗУУН ТӨГРӨГ			
XEND TO	Нэр Customer name ОМ ЦОГЦЭЦИЙН БАРЬЦАА БАНК Банк Beneficiary's bank 90 - ТӨРИЙН САН Дансны дугаар Account № 100111455410			Гарын үсэг Signature 1-p 1st 2-p 2nd
Үйлчилгээний хураамж Service charge 300.00				Тайлбар Stamp Өмнөговь АЙМАГ ПАБЛИК СЕРВИС ХХК 1125010061 3614263 СБТ27511
Гүйлгээний хураамж ХАСБАНК 5339 562		Огноо Date 12:43:51		Хянасан Checked by

Гүйлгээний ажилтан